

**Монгол Улсын тогтвортой
хөгжлийн зорилт ба Японы хүчин зүйл
(Техник, технологийн хамтын
ажиллагааны жишээн дээр)**

Ухнаагийн Загдцэсэм

*Эрдэм шинжилгээний дэд ажилтан, магистр,
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
Цахим хаяг: zagdtsesemi@mas.ac.mn*

Хураангуй: *Өгүүлэлд тогтвортой хөгжилд хүрэх арга зам болох ногоон технологи түүний ач холбогдол, Япон улсын аж үйлдвэржилт, шинжлэх ухаан, технологийн бодлогын хэрэгжилтийн туршилагатай уялдуулан Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Японы техник, технологийн хүчин зүйлийн нөлөө, холбогдлын талаар товч өгүүлэх болно.*

Түлхүүр үгс: *Аж үйлдвэрлэлийн хөгжлийн дараах нийгэм, тогтвортой хөгжил, Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт, Япон улсын шинжлэх ухаан, технологийн хүчин зүйл*

1. Тогтвортой хөгжлийн чиг хандлага ба Япон улсын шинжлэх ухаан, технологид суурилсан аж үйлдвэржилтийн бодлого

Байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр нийгэм, эдийн засгийн жигд хөгжилд хүрэхийг тогтвортой хөгжил гэх бөгөөд эдүгээ дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн загвараар хөгжихөөр нэгдсэн ойлголтонд хүрч, 2015 онд НҮБ-ын 70-р чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-ийг хэрэгжүүлэхийн төлөө зорьцгоож байна. Хөтөлбөрт “Шинжлэх ухаан, технологи, инновацийн тэгш хамтын оролцоотой ногоон технологийг аж үйлдвэрлэлд нэвтрүүлснээр ногоон эдийн засгийг хөгжүүлж, ядуурлыг бууруулж тогтвортой хөгжилд хүрнэ” хэмээн даян дэлхийн зорилт болгон дэвшүүлсний дагуу өндөр хөгжилтэй орнууд төрийн бодлогоо тодорхойлон судалгаа, холбогдох үйл ажиллагааг эрчимтэй өрнүүлж байна.

Тогтвортой хөгжлийн зарчим болох ёс зүйтэй хэрэглээг буй болгож эко системийг хадгалж үлдэх, ирээдүйн иргэдэд хэрэгцээгээ хангах боломжийг үлдээх зэрэг асуудлууд нь аж үйлдвэржсэний дараах нийгэм буюу мэдлэгийн нийгмийн үндсэн зарчмуудтай ч холбогддог байна.

Өнөөдөр дэлхийн өндөр хөгжилтэй, технологийн дэвшлээр тэргүүлж буй улс орнууд аж үйлдвэрийн IY хувьсгалын босгон дээр ирээд байна. Хүн төрөлхтөн XYII зууны сүүл XYIII зууны эхэн үеэс ус, уур болон механик хөдөлгүүрт төхөөрөмжүүдийг үйлдвэрлэлд

нэвтрүүлж аж үйлдвэрийн I хувьсгалыг эхлүүлж байжээ. Тэгвэл XX зууны эхэн үеэс эхэлсэн аж үйлдвэрийн II хувьсгалын онцлог нь эрчим хүч, цахилгаанжуулалт үйлдвэрлэлд нэвтэрч ажлын хуваарилалт нарийсч, массын үйлдвэрлэл нэмэгдсэн бол, 1970-аад оноос эхэлсэн III хувьсгалаар нийгэм эдийн засагт электрон бараа мэдээллийн технологи, үйлдвэрлэлийн автоматжуулалт нэвтэрснээрээ онцлогтой. Харин аж үйлдвэрийн IY хувьсгалын үр дүнд дижитал технологид суурилсан хиймэл оюун ухаан нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, цаг хугацаа, материал баялгийг хэмнэсэн хүний оролцоо туйлын бага технологи нь бидний амьдралд тааламжтай нөхцлийг бүрдүүлэх хэдий ч дижитал ертөнцөд нэвтрэх боломжтой улс орон, бүс нутаг, хэрэглэгчид уг хувьсгалаас хамгийн их өгөөжийг хүртэх нь улам бүр тодорхой болж байна. Товчхон хэлбэл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн ялгаатай байдал нь аж үйлдвэрлэлийн IY хувьсгалын эринд улс орнуудын хөгжлийн түвшин, хүн амын амьдралын чанарын ялгааг улам нэмэгдүүлэх болно.

Нөгөө талаар дэлхий нийтийг хамарсан байгалийн гамшиг, халдварт өвчин зэрэг даяаршлийн сорилттой тулгарч буй хүн төрөлхтөнд технологи, шинжлэх ухааны ололт дэвшлүүд улам бүр чухал болж буйг харуулж байна. Тухайлбал, Covid-19-той тэмцэж буй энэ цаг үед G20-ийн дижитал

эдийн засгийн сайд нарын ээлжит бус уулзалтыг 2020 оны 4-р сарын 30-ны өдөр видео хурал хэлбэрээр зохион байгуулж¹, халдвараас сэргийлэх арга хэмжээний хүрээнд интернэтээр ажлаа хийх явдал эрс нэмэгдсэн энэхүү нөхцөлд хүртээмжтэй, аюулгүй, хямд холболтыг эрс өргөжүүлэхэд хувийн хэвшил, ялангуяа харилцаа холбооны операторуудын нягт хамтын ажиллагаа чухал болохыг онцлов. Мөн дижитал технологийн хэрэглээг өргөжүүлэх, улс орон бүрийн хэрэгжүүлсэн дижитал бодлого, туршлагыг хуваалцах нь G20-ийн орнууд төдийгүй хөгжиж буй орнуудад үр дүнгээ өгнө хэмээн олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг онцлов. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн дэвшлээр тэргүүлэгч хөгжингүй орнуудын энэхүү өвчний эсрэг эмчилгээний эм, вакцин гарган авах шинжлэх ухааны нөр их ажилд хөгжиж буй улс орнууд ихээхэн найдвар тавьж байгаа билээ.

Тиймээс дижитал эдийн засагт суурилсан, мэдлэгийн нийгэмд амжилт олохын тулд Япон улсын эрдэмтэн Ёшиока Хитоши-гийн дурдсанчлан “... засгийн газар, аж үйлдвэрлэл, шинжлэх ухаан-судалгааны байгууллага, хувийн хэвшил гэсэн 4 салбарын цогц хамтын ажиллагаа”² зайлшгүй шаардлагатай ажээ.

АНУ-ын эрдэмтэн Даниел Белл 1960-аад онд шинжлэх ухаан, техникийн дэвшил нь нийгмийн

хөгжилд ихээхэн өөрчлөлт авч ирэх болно гэдгийг тэмдэглэж, эдийн засагт барааны үйлдвэрлэлээс гадна үйлчилгээний шинэ хэлбэр нэвтэрч, өмчийн тухай ойлголт өөрчлөгдөж, оюуны хөдөлмөр шингэсэн бүтээгдэхүүн гарч ирэхийг урьдчилан харж “Аж үйлдвэрлэлийн хөгжлийн дараах нийгэм (post industrialism)-ийн тухай онол”-ыг боловсруулсан.

Даниел Белл нийгэм, эдийн засгийн хөгжлөөр нь тухайн үеийн дэлхийн орнуудыг 3 хэсэгт хуваан³, АНУ-ыг аж үйлдвэрлэлийн хөгжлийн дараах нийгмийн шатанд хүрсэн гэж үзсэн. Үйлдвэрлэлд шинжлэх ухаан, мэдээлэл, техникийн дэвшил нэвтэрч, барааны үйлдвэрлэлээс гадна төрөл бүрийн үйлчилгээ нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарт өөрчлөлт гарсан нь АНУ-ын хөгжлийн онцлог хэмээжээ.

Баруун Европын орнууд, ЗХУ болон Япон улсыг аж үйлдвэр хөгжсөн нийгэмд оруулж, боловсруулах үйлдвэрлэл хөгжсөн, гэхдээ ажиллах хүчний мэргэжлийн түвшин дунд зэрэг, үйлдвэрлэлийн хаягдал, үргүй зардал ихтэй, орчин үеийн техник, технологийн нэвтрэлтийн түвшин доогуур, эдийн засгийн өсөлт нь материал, түүхий эд, ажиллах хүчнийг ихээр зарцуулж байж бий болдог орнууд гэж үзжээ.

1 Япон улсын Дотоод хэрэг харилцаа холбооны яамны сайт, G20デジタル経済大臣臨時会合 (テレビ会議) の開催結果(G20-дижитал эдийн засгийн сайд нарын ээлжит хуралдааны үр дүн), 2020.06.12. https://www.soumu.go.jp/menu_news/s-news/01tsushin06_02000202.html

2 中山茂、吉岡齊『科学革命の現在史-日本の持続可能な未来のために』学陽書房、2002年、頁5。(Накаяма Шигэрү, Ёшиока Хитоши “Шинжлэх ухааны хувьсгалын өнөөгийн түүх – Японы тогтвортой ирээдүйн төлөө” Гакүёошёбоо хэвлэлийн газар, 2002 он, 5-р тал.)

3 Б.Энхтүвшин Д.Моломжамц, Л.Хайсандай “Олон улсын эдийн засгийн харилцаа” УБ., 2013. 19-р тал.

Ази, Африк, Латин Америкийн орнуудыг аж үйлдвэрлэл хөгжсөн нийгмийн өмнөх шатанд оруулсан байна. Эдгээр орны эдийн засгийн хөгжил нь хөдөө аж ахуй дагнасан, загас агнуур, нүүрс олборлохоос цаашгүй, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэр хөгжөөгүй, мэргэжлийн ажиллах хүчингүй, эдийн засгийн бодлогод хуучин арга, давамгайлсан, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тодорхой ахиц өөрчлөлт гараагүй гэж дүгнэжээ.

Түүний боловсруулсан “Аж үйлдвэрлэлийн хөгжлийн дараах нийгмийн тухай онол” нь одоо хэр ач холбогдлоо алдаагүй хэвээр байна.

Япон улсын аж үйлдвэржилтийн бодлогын эхлэл тавигдсан цаг үе бол Өрнөдийн орнуудыг гүйцэж түрүүлэх зорилготой “Шинэчлэл” (近代化)-ийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн Мэйжигийн эрин (1868-1912 он)-д хамаарна. Дэлхийн II дайнаас өмнөх үед цэргийн хүчирхэг гүрэн болох замаар энэ зорилтыг шийдвэрлэж байсан бол дайнаас хойших хугацаанд эдийн засгийн хүчирхэг гүрэн болох замыг Япон улс сонгон авч, энэ зорилгод ард иргэдээ чиглүүлж, богино хугацаанд дайны өмнөх үеийн түвшинд хүрч чадсан билээ. 1949 оны 9-р сард “Аж үйлдвэрийг оновчтой зохион байгуулах тухай” гэсэн бодлогын

баримт бичгийг баталж, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд тэргүүний технологийг нэвтрүүлэх зэрэг зорилтыг тусгажээ⁴.

1961 онд Японы эрдэмтэн Акамацү Канама улсынхаа эдийн засгийг хөгжүүлэх тухай “Хөөж гүйцэх онол”⁵-оо гүнзгийрүүлэн боловсруулж, “экспортын чиглэлийн аж үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх боломжтой”⁶ гэж үзсэн. Япон улсын засгийн газар Акамацү-гийн онолын дагуу аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ шинжлэх ухаан, технологийг түлхүү хөгжүүлэх бодлогыг тасралтгүй залгамж чанартайгаар шат дараалан хэрэгжүүлжээ. Тухайлбал, 1962 онд “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө” (全国総合開発計画 - 全総), 1969 онд “Үндэсний хөгжлийн цогц шинэ төлөвлөгөө” (新全国総合開発計画 - 新全総), 1977 онд “Үндэсний хөгжлийн гуравдахь удаагийн цогц төлөвлөгөө” (第三次全国総合開発計画 - 三全総), 1987 онд “Үндэсний хөгжлийн дөрөвдэх удаагийн цогц төлөвлөгөө” (第四次全国総合開発計画 - 四全総), 1998 онд “Япон улсын газар нутгийн 21-р зууны Гранд дизайн” (21世紀の国土のグランドデザイン - 21GD), 2008 онд “Япон улсын газар нутгийн зохион байгуулалтын төлөвлөгөө” (国土形成計画)-г тус тус

4 Ц.Багбаяр “Монгол, Хятад Япон орон судлалын өгүүллүүд” УБ., 1996, 109-р тал.

5 Японы эрдэмтэн Акамацү Канама-гийн боловсруулсан “Хөөж гүйцэх онол” (“The flying geese pattern of development”). Энэхүү онол нь эрдэмтэн Акамацүгийн анх 1930-аад оны дунд үед бичсэн “Эдийн засгийн хөгжлийн ерөнхий онол”-ын нэгэн хэсэг бөгөөд 1961, 1962 онд англи хэлээр хэвлэгджээ.

6 南亮進「日本の経済発展」東洋経済新報社、2002年、頁165。(Минами Рёошин “Японы эдийн засгийн хөгжил” Тоёо кэйзай шинхоо хэвлэлийн газар, 2002 он, 165-р тал.)

баталж⁷, аж үйлдвэрийн шинэ хотуудыг бүс нутагт байгуулж, иргэдийн ажлын байр орлого, нийгмийн асуудлыг цогцоор шийдэж, томоохон хотууд дахь хүн амын төвлөрлийг сааруулж, бүс нутгийн хөгжлийн ялгааг бууруулж чадсан нь японы эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинэ шатанд хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Дээрх төлөвлөгөөнүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдсан “Өндөр технологийн төвлөрөл бүхий аж үйлдвэрлэлийн хотын тухай хууль”⁸ (テクノポリス法)-ийг 1983 онд баталж, 1998 он гэхэд 26 бүс нутгийг өндөр технологийн төвлөрөл бүхий аж үйлдвэрлэлийн хот болгон хөгжүүлсэн байна. Мөн “Шинжлэх ухаан, технологийн суурь хууль”⁹(科学技術基本法)-ийг 1995 онд баталж, 1996 оноос “Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үндсэн төлөвлөгөө” (科学技術基本計画)-г 5 жилийн шатлалаар 4 удаа амжилттай хэрэгжүүлснээр Даниел Белл-ийн тодорхойлсон аж

үйлдвэрлэлийн хөгжлийн дараах нийгмийн шатанд хүрч чаджээ. Дээрх бодлогыг хэрэгжүүлэх явцад шинжлэх ухаан, технологийн хөгжилд зарцуулах зардлыг жил бүр нэмэгдүүлж¹⁰, 2019 оны байдлаар шинжлэх ухааны судалгаанд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, судлаачдын тоогоороо Их 7-гийн орнуудын дотор 3-рт орж байна¹¹.

Ийнхүү Япон улсын үе үеийн засгийн газар аж үйлдвэржилт, шинжлэх ухаан, технологийн талаар тууштай бодлого баримталж, тодорхой төлөвлөгөөнүүдийг амжилттай хэрэгжүүлэхдээ түүнд шаардагдах төсөв хөрөнгийг нарийн тооцож зориулалтын дагуу зарцуулж, тухай бүрт нь хяналт үнэлгээг хийж иржээ. Энэхүү туршлагыг манай улс онцгойлон анхаарч, хөгжлийн бодлого, зорилтуудаа төлөвлөсөн хугацаанд амжилттай хэрэгжүүлэхэд тус болох зарим туршлагаас нарийн судалгааны үндсэн дээр нутагшуулан ашиглах бүрэн боломжтой юм.

7 Ред. Ц.Баатар “Японы ногоон хөгжлийн туршлага” Тод бичиг хэвлэлийн компани, УБ., 2017, 17-19-р тал. 『地域政策研究』(高崎経済大学地域政策学会)第9巻、第2・3合併号、2007年2月、229頁～239頁。(“Бүс нутгийн бодлогын судалгаа” (Такасаки эдийн засгийн их сургууль, Бүс нутгийн бодлогын нийгэмлэг) 9-р боть, № 2.3, 2007 оны 2-р сар, 229-239-р тал. Hiroshi Mitsuhashi “In regional industrial policy, change of “regional concept” - case study of cluster policy -”)

8 Япон улсын Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны сайт, Шинжлэх ухаан, технологийн системийн шинэчлэл, 2020.06.12. https://www.mext.go.jp/b_menu/hakusho/html/hpbb200301/hpbb200301_2_067.html

9 中山茂、吉岡斉『科学革命の現在史-日本の持続可能な未来のために』学陽書房、2002年、頁35。 (Накаяма Шигэру, Ёшиока Хитоши “Шинжлэх ухааны хувьсгалын өнөөгийн түүх – Японы тогтвортой ирээдүйн төлөө” Гакүёшөёбоо хэвлэлийн газар, 2002 он, 35-р тал.)

10 Мөн тэнд. 36-р тал.

11 Япон улсын Шинжлэх ухаан технологи, судалгааны бодлогын үндэсний хүрээлэн (NISTEP)-гээс гаргасан “Шинжлэх ухаан технологийн индекс 2019” эмхэтгэлд, 2020.06.12. <https://www.nistep.go.jp/archives/41356>

2. Монгол Улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Японы техник, технологийн хүчин зүйл

Аж үйлдвэрлэлийн ГҮ хувьсгал эхлэн буй энэ үед Монгол улс дэлхийн хөгжлийн хаана нь явна вэ? Дэлхийн хөгжилтэй хэрхэн хөл нийлүүлэн алхах вэ? гэдэг асуудлууд бидний өмнө тулгарч байна.

Монгол улс ХХ зууны 80-аад он гэхэд хөдөө аж ахуйн түүхий эдээ боловсруулж, нэмүү өртөг шингэсэн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эдийн засгийн бүтцийн хувьд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн орны эгнээнд орж байсан. Тухайлбал, “манай улсын аж үйлдвэрийн салбар нь боловсруулах аж үйлдвэр, хүнсний үйлдвэрлэл, уул уурхайн аж үйлдвэр, түлш эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэл гэсэн салбаруудаас бүрдэх болж, 1990 оны байдлаар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд боловсруулах аж үйлдвэр 26.8%, хүнсний аж үйлдвэр 20.0%, уул уурхайн аж үйлдвэр 26.7%, түлш эрчим хүч үйлдвэрлэл 15.5%, барилгын материалын үйлдвэрлэл 10.8%”¹²-ийг эзэлж байсан бол экспортын бүтээгдэхүүний 30%-ийг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, уул уурхайн бүтээгдэхүүн 20%-ийг бүрдүүлдэг байжээ.¹³ Тэгвэл 2019 оны байдлаар “төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын 98.5% буюу нийт экспортын 83.0%”¹⁴-ийг эзэлж байна.

Ийнхүү аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц өөрчлөгдөж уул уурхайн олборлолтод түшиглэсэн хүрэн эдийн засагт шилжсэн нь бодлогын ноцтой алдаа болсныг харуулж байна. Энэхүү алдааг аль болох богино хугацаанд засч тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжлийн замд ороход Засгийн газраас аж үйлдвэржилтийн талаар оновчтой бодлого явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг тууштай хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

2016 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд *“макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ”* хэмээн заасан.

Мөн 2020 оны 5 дугаар сарын 12-нд УИХ-аар хэлэлцэн баталсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт *“... эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүртээ*

12 Б.Батхшиг “Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал” УБ., 2018, 146-147-р тал.

13 Т.Намжим “Монгол улсын эдийн засаг” 2-р боть, УБ., 2004.

14 Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын сайт, “Гадаад Худалдааны Барааны Статистик Мэдээлэл”, 2020.06.12. <http://customs.gov.mn/news/daily/latest/1928-2019-10>

хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” хэмээн заасан.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын гуравдагч хөрш Япон улсын шинжлэх ухаан, тэргүүний технологид суурилсан аж үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн туршлага, техник, технологийн хүчин зүйл чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Япон улс нь манай оронтой нэг бүс нутагт оршиж, бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцийн тэргүүлэх байр суурийг эзэлдэг, шинжлэх ухаан, технологийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлдэг, шинээр аж үйлдвэржсэн орнуудын эрчимтэй хөгжлийн загвар орон. Манай улстай харилцах харилцааны хувьд ардчилал, эдийн засгийн шинэчлэлтийг хоёр талын харилцааны болон олон улсын тавцанд эхнээс нь тууштай дэмжиж, эдийн засгийн шилжилтийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад жинтэй хувь нэмэр оруулж, Монгол улсын эдийн засгийн төрөлжилт, тогтвортой хөгжлийн төлөө идэвхтэй хамтран ажиллаж буй орон.

Монгол улс ардчиллын үйл явц

өрнөж эхэлсэн цаг үеэс Япон улстай харилцах харилцааг чухалчилж, тус улсын техник, технологийг нэвтрүүлэх талаар эрэлхийлж ирсэн. Тухайлбал, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном өрнөдийн орнуудаас анх удаа 1990 оны 3 дугаар сард Япон улсад айлчлах үеэрээ, “Монгол улсын голлох аж үйлдвэр болох мал аж ахуйн болон бусад түүхий эдийг боловсруулах зэрэг үйлдвэрлэлийг өргөжүүлэхийн тулд Японы орчин үеийн технологийг нэвтрүүлэхийг хүсч байна”¹⁵ хэмээн Японы технологид ихээхэн найдвар тавьж буйгаа илэрхийлж байв.

Хоёр талын идэвхтэй хүчин чармайлт хийгээд, Монгол улсын олон тулгуурт, бие даасан гадаад бодлогын үр дүнд Монгол Японы харилцаа богино хугацаанд олон салбарыг хамран гүнзгийрч 1997 онд “Иж бүрэн түншлэлийн харилцаа”-нд шилжиж, 2010 онд “Стратегийн түншлэлийн харилцаа”-нд дэвшиж, төрийн тэргүүнүүдийн харилцан айлчлал тогтмолжиж, хоёр орны хамтын ажиллагааны талаарх баримт бичгүүд байгуулагдан хэрэгжиж ирлээ. Манай улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн санал санаачилгыг Японы талаас удаа дараа дэвшүүлж ирлээ. Тухайлбал, “Эрч” санаачилга¹⁶, “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2013-2017)”

15 Японы Монгол судлалын нийгэмлэгийн хэвлэл-“Япон ба Монгол:Найрамдал” сэтгүүл, 1990 он, №80., “Бие даасан байдлыг эрмэлзэж буй Монголын хувьсгал” 1990 оны Монголын Ардчилсан хувьсгалын талаарх япон сурвалжлагч нарын тэмдэглэл, эрхлэн хэвлүүлсэн О.Батсайхан, “Бит пресс”хэвлэлийн газар, УБ., 2019, 30-р тал.

16 Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ хоёр орны Стратегийн түншлэлийн харилцааг эрх чөлөө, ардчилал, энх тайван, бие биедээ харилцан туслах үзэл санааны дагуу бэхжүүлэн хөгжүүлэх санал гаргаж, улмаар Монгол улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2013 онд дэвшүүлэв.

(2013 он), “Эрч+” санаачилга¹⁷, “Аж үйлдвэр, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хамтын ажиллагааны санамж бичиг” (2015 он)-ийг дурдаж болно. Мөн “Монгол Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” (2016 он), “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021 он)” (2017 он)-ийг тус тус батлан хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, соёл, иргэд хоорондын харилцаа, хүний нөөцийг бэхжүүлэх хүрээнд харилцан ойлголцол, найрамдал нөхөрлөлийг бататган хөгжүүлэхийн төлөө бүх түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэхийг зорьж байна. Мөн эдгээр баримт бичгүүд нь Японы тэргүүний техник, технологи манай улсад нэвтрэх эрх зүйн таатай орчин болж байна.

Хоёр орны эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Япон улсын техник, технологи манай улсад нэвтрэхэд дараах зүйлүүд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Япон улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) ихээхэн үүрэг гүйцэтгэж ирлээ.

1977 онд байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт үндэслэн Япон улсаас Монгол улсад “Товь” ноолуурын үйлдвэрийг барьж, байгуулах буцалтгүй хөрөнгийн тусламж үр дүнгээ өгч эдүгээ манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбараас дэлхийд өрсөлдөх чадвар бүхий брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр болтлоо хөгжсөн юм.

Мөн Японы засгийн газрын хөгжлийн буцалтгүй тусламжийн хүрээнд томоохон төслүүдийг хэрэгжүүлж цахилгаан станц, харилцаа холбоо, тээврийн зэрэг дэд бүтцийн салбарт; мах боловсруулах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үр тариа хадгалах байгууламж болон хөдөө, аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх гэх мэт хөдөө, аж ахуйн салбарт; эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх гэх мэт эрүүл мэндийн салбарт; хогны машин, гал унтраах машин зэрэг гамшиг, эрүүл ахуйн зориулалт бүхий автомашин нийлүүлэх гэх мэт бүхий л салбарын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нийлүүлсээр иржээ.

Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нийлүүлэхээс гадна техникийн хамтын ажиллагааны хүрээнд “Дулааны IY цахилгаан станцийн хүчин чадлыг сайжруулах судалгаа”, “Зүүн хойт бүс нутгийн төв замыг сайжруулах хөгжлийн судалгаа”, “Нүүрсний салбарын мастер төлөвлөгөө 2014-2025” гэх зэрэг хөгжлийн судалгааны олон төсөл хэрэгжүүлж, технологид сургах үйл ажиллагааг хийж ирэв. Эдгээрээс зарим жишээ дурдвал, “Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг 2010 оноос хэрэгжүүлж, агаарын бохирдлын хэмжилтийн техник, технологийг сайжруулж, японы байгаль орчны бодлого, тогтолцоотой холбоо бүхий туршлагаас хуваалцан техникийн зөвлөгөө өгч байна. Мөн 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Хөдөөгийн бага

17 Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ “Монголын экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго”-оор 2014 онд дэвшүүлсэн.

боловсролын чанарыг сайжруулахад мэдээллийн харилцааны технологийг оновчтой ашиглах нь төсөл¹⁸-ийг 2023 он хүртэл хэрэгжүүлэхээр тохирч, орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, хот хөдөөгийн сургалтын ялгааг арилгахад мэдээллийн технологийг ашиглах, орчин үеийн боловсролын хөгжлийн загвар болгох зорилт тавьж хамтран ажиллаж байна. 2019 оноос “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл¹⁹-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслөөр Монгол Улсын тогтвортой хөгжилд чиглэсэн бүсчилсэн хөгжлийн дүр зураг, хөгжилд хүрэх арга замыг тусгасан үндэсний хэмжээний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулахыг зорьж байгаа юм. Эдгээр судалгааны хөндсөн асуудал, арга зүй, санал дүгнэлт зэргийг бодлого боловсруулах үйл явцад зайлшгүй анхааран үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Ялангуяа иэнийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар яг одоо хэрэгжүүлж, эхнээсээ ашиглалтад орж байгаа дараах төслүүдээр дамжиж Японы орчин үеийн тэргүүний технологи эзэмшихэд суралцах, Монгол улсад нутагшуулах боломж бүрдэж байна.

- “Инженер, технологийн дээд боловсрол” төслөөр нэгд, Монгол

улсад нэн шаардлагатай аж үйлдвэр, техник, технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, хүчин чадлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 7.5 тэрбум иэнийн өртөгөөр 2014-2023 онд 1000 инженер бэлтгэхээр оюутан залуусыг Япон улсад сургаж байгаа бол хоёрт, 30 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй сургалт, судалгааны тоног төхөөрөмж худалдан авахаар тохиролцож, эхний ээлжийн тоног төхөөрөмжүүдийг ШУТИС-ийн лабораторид суурилуулаад байна.

- “Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг барих төсөл”-ийг одоогийн нисэх буудлын үйлчилгээнд тулгарч буй хүндрэлийг арилгах, нислэгийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлэх, агаарын тээвэрлэлтийг тогтворжуулах, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор 65,6 тэрбум иэнийн хөнгөлөлттэй зээл (40 жилийн хугацаатай, эхний 10 жилд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө)²⁰-ээр хэрэгжүүлж буй бөгөөд жилд 3 сая зорчигч, 12 мянган онгоц хүлээн авах хүчин чадалтай иргэний нисэхийн олон улсын стандартад нийцсэн нислэг хөдөлгөөний удирдлагын орчин үеийн тоног төхөөрөмж, навигацийн тоноглолоор хангагдсан иж бүрэн цогцолбор хэлбэрээр барьж байгуулж байна. УИХ-ын 2013 оны

18 ЖАЙКА (JICA- Japan International Cooperation Agency)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 9 дүгээр сарын дугаар. Мэдээллийн харилцааны технологи (ICT) ба багш нарын сургалтын материалыг боловсруулах төсөл, 2020.06.12. <https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm000001jw11-att/newsletter201809.pdf>

19 ЖАЙКА (JICA- Japan International Cooperation Agency)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2019 оны 1 дүгээр сарын дугаар. Төслийн хэрэгжилт, 2020.06.12. <https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm000001jw11-att/newsletter201901.pdf>

20 Монгол Улсын Засгийн газар, Зам тээврийн хөгжлийн яамны сайт, “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн танилцуулга, 2020.06.12. <https://mrttd.gov.mn/i/1726>

18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д “Шинээр барих олон улсын нисэх буудлыг ЗХА-ийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгон тус нисэх буудлын нутаг дэвсгэрийг оролцуулан эдийн засгийн чөлөөт бүс байгуулна” хэмээн бодлого, зорилтыг тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 сарын 28-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг “хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх” нөхцөлөөр Монгол, Японы хамтарсан компанитай концессын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Монголын талаас “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, Японы консорциум буюу “Жапан Эйрпорт Менежмент” ХХК-ийн хамтарсан “Нью интернэйшнл эйрпорт” ХХК-д концессоор шилжүүлсэн юм²¹. Уг гэрээ 15 жил хэрэгжих бөгөөд концесс эзэмшигчид гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дотор өөрийн хөрөнгөөр бэлтгэл ажлыг ханган шинэ нисэх буудлын ажлыг албан ёсоор эхлүүлэх юм. Шинэ нисэх буудал ашиглалтанд орсноор нисэх буудлын удирдах менежментийн арга барилд манай улс суралцаж, Японы технологи ноу хау нэвтрэх боломж бүрдэж байна.

- Япон улсын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Монгол-Японы сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл”-өөр АШУҮИС-ийн харьяанд Баянзүрх дүүрэгт баригдсан Монгол Япон сургалтын эмнэлэг 2019 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Япон улсын дэвшилтэт тоног төхөөрөмжөөр тоноглогдсон (Сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий МЯ1, КТ зэрэг дүрс оношилгооны тоног төхөөрөмж, судсан дотуурх оношилгооны иж бүрдэл, лабораторийн бүрэн автомат анализатор гэх мэт 360 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмж), эмнэлгийн тусламж үйлчилгээний энэхүү эмнэлэг нь амбулатори, лекцийн танхим, хурлын өрөө, номын сангаас бүрдсэн сургалтын хэсэг, хэвтэн эмчлүүлэх гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэж, япон стандартыг нэвтрүүлэн ажиллахаар зорьж байна. Тус эмнэлэг нь нэгд, хотын иргэдийн эмнэлэгийн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулж, хоёрт, орчин үеийн тоног төхөөрөмж дээр оюутан, залуус дадлагажих, гуравт, сургалтын байгууллагаас илүү эмчилгээний орчиндоо суралцах, дөрөвт, анагаахын чиглэлийн олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг явуулах зэрэг олон давуу талыг олгож байна.

Ийнхүү Япон улсын Засгийн газар манай улсад үзүүлж буй эдийн засгийн дэмжлэг тусламжийн үндсэн

21 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын сайт, “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлын менежмент”-ийн концессын гэрээг байгууллаа. 2020.06.12. <http://nda.gov.mn/1559.html>

чиглэлээ “эдийн засгийн өсөлтийн үр шим бүх давхаргад жигд хүртээмжтэй байх; хөгжлийн бүх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх; эдийн засгийн тогтвортой өсөлт, тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих” хэмээн тодорхойлсны дагуу Монгол улсын хөгжлийн зорилго, зорилтууд, нийгэм, эдийн засагт тулгамдаж буй хүнд хэцүү асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Хоёрдугаарт, Монгол улсын Засгийн газар Япон улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” (ЕРА, 2016)-ийг амжилттай хэрэгжүүлж чадвал хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжих, байгаль орчинд ээлтэй японы дэвшилтэд техник, технологи манай улсад нэвтрэн технологийн шинэчлэлт хийгдэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Манай улсын хөгжлийн тэргүүлэх зорилт нь экспортод чиглэсэн олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгон экспорт давамгайлсан гадаад худалдааг хөгжүүлэх явдал юм. Ийм бүтцийг бий болгож хөгжүүлэхэд гадаад таатай орчин бүрдүүлэх нь хамгаас чухал. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа чухал байр эзэлдэг.

Япон улстай байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр” нь манай улсын байгуулсан анхны чөлөөт худалдааны хэлэлцээр бөгөөд

улс төр, эдийн засгийн чухал ач холбогдолтой хэлэлцээр болсон юм.

Ялангуяа манай улс “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийг Япон улстай байгуулснаар Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан “гуравдагч хөрш”-ийн бодлогыг эдийн засгийн агуулгаар баталгаажуулахад томоохон түлхэц болж байна. Цаашилбал, гадаад зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж бүс нутгийн интеграци, үйлдвэрлэлийн сүлжээнд нэгдэн орох, японы хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд энэхүү хэлэлцээр чухал хувь нэмэр оруулах болно.

Гуравдугаарт, Хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт нь технологийн шилжилт явагдахад нөлөөлдөг нэг гол хүчин зүйл гэж судлаачид үздэг. Манай улсын санаачилгаар “Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Монгол улс, Япон улсын Засгийн газрын хэлэлцээр”-ийг 2001 онд байгуулсан. Харин 2016 онд байгуулагдсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” нь хоёр орны хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал баримт бичиг болж буй бөгөөд “хоёр талын хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хамгаалах” зорилгоор тус хэлэлцээрийн 10 дугаар бүлэгт хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинг тусгайлан зааж өгсөн юм.

Монгол улсын Ерөнхий сайд

У.Хүрэлсүхийн 2018 оны 12 дугаар сард Япон улсад айлчлах үеэр хоёр орны ерөнхий сайд нар тохиролцсоны дагуу Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын дэргэд гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг 2019 оны 1 дүгээр сараас нээж, тус төвөөр дамжуулж Монгол дахь Японы хөрөнгө оруулалтыг тэлэх чиглэлд дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

2018 оны байдлаар Монгол улсад Японы хөрөнгө оруулалттай 640

компани, хамтарсан аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. 1990-2018 оны хооронд Япон улсаас Монгол улсад нийт 823 сая ам.долларын²² хөрөнгө оруулалт хийгдсэний тал хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт, үлдэх нь банк, санхүү, аялал жуулчлал, барилга, мэдээллийн технологийн салбарт ногдож байна. Япон хөрөнгө оруулалттай компаний үйл ажиллагаа нь тухайн салбарт менежментийн шинэ туршлага, тэргүүний технологи нэвтэрч нутагшихад чухал ач холбогдолтой байх болно.

Дүгнэлт

1. Монгол улсад үзүүлж буй Япон улсын Засгийн газрын ХАЁТ-ийн хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдээр дамжиж японы техник, технологи манай улсад шууд болон хүний хөгжлөөр дамжин нэвтэрч ирсэн. Үүний үр дүн нь эхнээсээ гарч буй бөгөөд Монгол улсын цаашдын хөгжилд томоохон хувь нэмэр оруулах болно.
2. Монгол улсын засгийн газар Япон улсын засгийн газрын хооронд байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийг амжилттай хэрэгжүүлэх үйл явц нь Японы техник, технологид суралцах чухал боломж гэж үзэж байна.
3. Япон улсын туршлагаар экспортын чиглэлтэй, ногоон технологи бүхий жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж, түүхий эдийн экспортоор дагнасан бүтцийг өөрчлөх; эрдсийн болон мал аж ахуй, амьтан ургамлын гаралтай түүхий эдийг өндөр түвшинд боловсруулж дотоодынхоо хэрэгцээг хангаж, цаашид дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлогыг залгамж шинжтэйгээр үргэлжлүүлж бодит ажил хэрэг болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

22 Үндэсний хөгжлийн газар Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын газрын мэдээ

Ашигласан материал

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он.
- Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он.
- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал
- “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021 он)” 2017.03.29 Токио.
- Ред. Ц.Баатар “Японы ногоон хөгжлийн туршлага” Тод бичиг хэвлэлийн компани, УБ., 2017.
- Ц.Батбаяр “Монгол, Хятад Япон орон судлалын өгүүллүүд” УБ., 1996.
- Б.Батхишиг “Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал” УБ., 2018.
- Т.Намжим “Монгол улсын эдийн засаг” 2-р боть, УБ., 2004.
- Б.Энхтүвшин Д.Моломжамц, Л.Хайсандай “Олон улсын эдийн засгийн харилцаа” УБ., 2013.
- “Олон улсын харилцаа” сэтгүүл, УБ., 2017 №1/107
- 中山茂、吉岡斉『科学革命の現在史-日本の持続可能な未来のために』学陽書房、2002年。(Накаяма Шигэрү, Ёшиока Хитоши “Шинжлэх ухааны хувьсгалын өнөөгийн түүх – Японы тогтвортой ирээдүйн төлөө” Гакүёошөбоо хэвлэлийн газар, 2002 он.)
- 南亮進「日本の経済発展」東洋経済新報社、2002年。(Минами Рёшин “Японы эдийн засгийн хөгжил” Тооёо кэйзай шинхоо хэвлэлийн газар, 2002 он.)
- 『地域政策研究』（高崎経済大学地域政策学会）第9巻、第2・3合併号、2007年。(“Бүс нутгийн бодлогын судалгаа” (Такасаки эдийн засгийн их сургууль, Бүс нутгийн бодлогын нийгэмлэг) 9-р боть, № 2,3, 2007 он. Hiroshi Mitsuhashi “In regional industrial policy, change of “regional concept” - case study of cluster policy -”)
- Япон улсын Шинжлэх ухаан технологи, судалгааны бодлогын үндэсний хүрээлэн (NISTEP)-гээс гаргасан “Шинжлэх ухаан технологийн индекс 2019” эмхэтгэлд <https://www.nistep.go.jp/archives/41356>

- Японы Монгол судлалын нийгэмлэгийн хэвлэл-“Япон ба Монгол:Найрамдал” сэтгүүл, 1990 он, №80. “Бие даасан байдлыг эрмэлзэж буй Монголын хувьсгал” 1990 оны Монголын Ардчилсан хувьсгалын талаарх япон сурвалжлагч нарын тэмдэглэл, эмхэтгэн хэвлүүлсэн О.Батсайхан “Бит пресс” хэвлэлийн газар, УБ., 2019.
- Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын сайт, “Гадаад Худалдааны Барааны Статистик Мэдээлэл”, 2020.06.12. <http://customs.gov.mn/news/daily/latest/1928-2019-10>
- Япон улсын Дотоод хэрэг харилцаа холбооны яамны сайт, G20デジタル経済大臣臨時会合（テレビ会議）の開催結果(G20-дигитал эдийн засгийн сайд нарын ээлжит хуралдааны үр дүн), 2020.06.12. https://www.soumu.go.jp/menu_news/s-news/01tsush-in06_02000202.html
- ЖАЙКА (JICA- Japan International Cooperation Agency)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 9 дүгээр сарын дугаар. Мэдээллийн харилцааны технологи (ICT) ба багш нарын сургалтын материалыг боловсруулах төсөл, 2020.06.12. <https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm000001jw11-att/newsletter201809.pdf>
- ЖАЙКА (JICA- Japan International Cooperation Agency)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2019 оны 1 дүгээр сарын дугаар. Төслийн хэрэгжилт, 2020.06.12. <https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm000001jw11-att/newsletter201901.pdf>
- Монгол Улсын Засгийн газар, Зам тээврийн хөгжлийн яамны сайт, “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн танилцуулга, 2020.06.12. <https://mrtd.gov.mn/i/1726>
- Үндэсний хөгжлийн газар Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын газрын мэдээ

Mongolia's sustainable development goals and the Japanese factor (Issues on technical and technological cooperation)

Zagdtsesem Ukhnaa

*Research Fellow, MA, Institute of International Affairs, Mongolian Academy of
Sciences*

Ulaanbaatar, Mongolia

E-mail: zagdtsesemu@mas.ac.mn

Abstract: *The article briefly describes the importance of green technology as a way to achieve sustainable development, the impact of Japanese technical and technological factors on the implementation of Mongolia's sustainable development goals in connection with Japan's industrialization, science and technology policy implementation experience.*

Keywords: *Post-industrial society, sustainable development, Mongolia's sustainable development goals, Japan's science and technology factors*

<i>The day of submission:</i>	2020.6.5
<i>Completion of review:</i>	2020.6.18
<i>Final decision for acceptance:</i>	2020.6.20